Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 1-р сарын 7 -ны өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

Аймгийн ИТХ-д 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт тэргүүлэгчид , ажлын албаны ажлын төлөвлөгөө

| Анги, бүлэг, д/д | Хийх ажил | Хэрэг-жүүлэх хугацаа | Хариуцан гүйцэтгэх хүн, байгууллага | Хэрэгжилтэнд хяналт тавих хүн | Нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Нэг** | **Хурлын дотоод зохион байгуулалтын асуудал** | | | | |
| **1.** | **Аймгийн ИТХ-ын хуралдааны**г 3 хүртэл удаа зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлэх.Үүнд: | Жилдээ | Тэргүүлэгчид | Ч.Чимэд | 3 хүртэл удаагийн хуралдаан хийх |
| 1-1,2 | Оны дундуур хийгдэх хуралдаануудаар<br>а/Төсвийн тодотгол<br>б/ "Их наяд-Увс " хөтөлбөр<br>в/Мэргэжлийн боловсрол,сургалтын талаарх аймгийн бодлого<br>г/Аймгийн 90 жилийн ойн бэлтгэл, зохион байгуулалт<br>д/ Цаг үеийн бусад асуудлууд | 1,2-р улиралд | Тэргүүлэгчид, ЗДТГ,хороод | Ч.Чимэд, Д.Цэндсүрэн | Зохих тогтоол шийдвэрүүд болон хөтөлбөр боловсруулагдаж батлагдсан байна |
| 1-3 | Оны төгсгөлийн ээлжит хуралдаанаар<br>а/ИТХ-ын 2015 оны ажлын тайлан<br>б/Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, 2015 оны зорилтын хэрэгжилт<br>в/Аймгийн 2016 оны зорилт, ОНХС-аар хийгдэх ажлын жагсаалт<br>г/2014 оны төсвийн гүйцэтгэл,2016 оны төсвийн төсөл<br>д/2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө<br>е/ Цаг үеийн бусад асуудал | 11-р сард | -"- | -"- | -"- |
| **2.** | **Тэргүүлэгчдийн** хурлыг төлөвлөгөөний дагуу сар бүр, цаг үеийн асуудлаар тухай бүрийд нь зарлан хуралдуулж дараах төлөвлөсөн болон бусад тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлүүлэх. Үүнд: | Сар бүр | Тэргүүлэгчид, ажлын алба | Ч.Чимэд | Төлөвлөгөөний дагуу хурал болж хэлэлцсэн асуудлаар зохих шийдвэр гарсан байх |
| 2-1-1 | Аймгийн ИТХ-ын 2015 оны ажлын төлөвлөгөө | 1-р сар | Б.Оюунбат | Ч.Чимэд | |
| 2-1-2 | Улсын сайн малчин, тэргүүний тариаланч цолоор шагнуулах малчид, тариаланчдыг шагналд тодорхойлох | 1-р сар | ХБХ, ХХААГ | З.Ганболд, Ж.Александр | |
| 2-1-3 | Аймгийн оны аврага тэргүүний хүмүүсийг шалгаруулах болзолын төсөл, 2014 оны ажлаар аймгийн тэргүүний сум байгууллага, иргэдийг шалгаруулах тухай | 1-р сар | ЗДТГ-ын ТЗУХ Д.Баяраа | Г.Болорэрдэнэ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2-1-4 | Улаангом болон бусад сумдад баг зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар авах зарим арга хэмжээний тухай | 2-р сар | Д.Баяраа, О.Ганхуяг | Д.Цэндсүрэн | |
| 2-1-5 | Мэргэжлийн боловсрол сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай | 2-р сар | Ч.Наранбилэг, МБСАСЗ | Б.Цэцээ | |
| 2-1-6 | Хатан түрүү ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны тайлан | 3-р сар | ТУЗ, Б.Баяртсайхан | Ч.Чимэд | |
| 2-1-7 | Худалдан авах ажиллагааны үр дүн,сургамж, шийдвэрлэх асуудал | 4-р сар | ХАА алба | Л.Цогтсайхан | |
| 2-1-8 | Галдан бошигт хааны нэрэмжит “Сүр овоо “ босгох тухай | 4-р сар | “Тод номын гэрэл” төв | Г.Болорэрдэнэ, На.Сүхбаатар | |
| 2-1-9 | Худалдаа үйлчилгээний төвүүд болон цэг салбаруудын үйл ажиллагаа, бүх төрлийн үйлчилгээнд стандартыг хангуулж, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах , энэ талаар байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхижүүлэх шаардлага, шийдвэрлэх асуудлын тухай | 5-р сар | МХГ, СХЗТ | Ч.Орлом, Г.Ууганбаяр | |
| 2-1-10 | Нөхөн сэргээх хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэх,ашигт малтмалын талаар баримтлах аймгийн бодлогын тухай | 6-р сар | ХБХэлтэс | З. Ганболд | |
| 2-1-11 | Улаангом хот, Арсай зэрэгт газар олголтыг цэгцлэх, цэвэр усны эх үүсвэрийг хамгаалах, хог бүхий талбайг цэвэрлэж сэргээх, нийтийн оршуулгын газрыг шинээр төлөвлөх, гудамж төслийг хэрэгжүүлэх зэрэг хотын хөгжил, төлөвлөлт, газар зохион байгуулалтын талаарх шийдвэрлэх асуудлууд | 7-р сар | ГХБХБА,Улаангом сумын ИТХ, ЗДТГ, хотын ХЦГазар | Г.Отгонболд, Б.Жавхлантөгс, О.Ганхуяг, Ё.Мөнхзул | |
| 2-1-12 | Урлаг,соёл, уран бүтээлийн аймгийн нэрэмжит шагнал бий болгох тухай | 8-р сар | Санаачлагч дын хэсэг | Б. Норов, Д. Бямбажав | |
| 2-1-13 | Ном, Авьяас хөтөлбөрийн хэрэгжилт, сурагчдын дүрэмт хувцасны олголт болон боловсролын үйлчилгээг цаашид боловсронгуй болгох асуудал , “Сэтгэдэг сургууль-Бүтээдэг аймаг” зорилтын хэрэгжилт | 9-р сар | Аймгийн ЗДТГ-ын НХХ, БСГ | Б.Ядамсүрэн, Ц.Идэрбат | |
| 2-1-14 | Нярай, 0-5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, эрүүл мэндийн суурь үзүүлэлтийг дээшлүүлэх, хавдрын аяны урьдчилан сэргийлэх ажлыг хүртээмжтэй болгох зэрэг эрүүл мэндийн үйлчилгээний шийдвэрлэх асуудлууд болон эрүүд мэндийн үзлэгт бүх хүн амыг хамруулах зорилтын хэрэгжилт | 10-р сар | Аймгийн ЗДТГ-ын НХХ, ЭМГ | Б.Ядамсүрэн, Д.Дулмаа | |
| 2-1-15 | “Шинэ Улаангом” ОНӨААТУҮГ-ын ажлын тухай мэдээлэл | 11-р сар | Х.Нямаа, ТУЗ, Н.Энхжаргал | Ч.Чимэд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2-2**<br>2-2-1<br>2-2-2<br>2-2-3<br><br><br>2-2-4 | Дараах асуудлыг **тухай бүрийд нь** хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх. Үүнд:<br>Иргэдийг төр засгийн болон бусад байгууллагын шагналд тодорхойлох<br>Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтын тухай<br>Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, хурлын хороод, төлөөлөгчид болон аймгийн Засаг дарга, сум байгууллага, иргэдээс тавьсан санал, хүсэлт, өргөдөл гомдол бусад цаг үеийн нийтлэг, тулгамдсан асуудал<br>Аймгийн ИТХ-ын хуралдааныг товлон зарлах, бэлтгэл хангах, хэлэлцүүлэхээр бэлтгэсэн төслүүдийг урьдчилан сонсож , боловсруулалтыг сайжруулах, чиглэл зөвлөмж өгөх | Сар бүр | Тэргүүлэгчид, Ажлын алба, ЗДТГ, хурлын хороод | | |
| **3** | **Хурлын хороод** эрхлэх асуудлынхаа хүрээнд дараах сэдэв , чиглэлээр иргэд байгууллагуудын оролцоог дээшлүүлэх, үүсгэл санаачлагыг дэмжих, санал судлах, хэлэлцүүлэг хийх, хяналт шалгалт явуулах, санал дүгнэлт гаргах, холбогдох сум байгууллагын ажилтай танилцах, энэ үеэрээ сум багийн Иргэдийн хуралд оролцож ажлын дүн, гарсан санал, шийдвэрлэх асуудлыг илтгэх хуудсаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид мэдээлж, тулгамдсан асуудлыг зохих шатанд тавьж шийдвэрлүүлэх зэргээр **улиралд 1-ээс доошгүй ажил** зохион байгуулах. Үүнд:<br>Аймгийн 90 жилийн ой угтсан бүтээн байгуулалтын ажлын хүрээнд | Жилдээ | Хорооны гишүүд, холбогдох байгууллагын болон ИТХ-ын ажлын албаны хороод хариуц сан ажилтнууд | Хороодын болон холбогдох байгууллагын дарга нар | Хороод тогтмол ажиллаж эрхлэх асуудлынхаа хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлж , төлөвлөгөөнд туссан асуудлаар улиралд 1 удаа ажил зохион байгуулж үр дүнгээ тайлагнасан байх |
| 3-1-1 | а “Өөрчлөлтийг өөрөөсөө эхлье “ хөдөлгөөн өрнүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сум байгууллага, айл өрхүүдийн орчны тохижилтыг сайжруулах аян явуулах | 3-р сараас | ХЭЗДХ-ын хороо, хотын ХЦГазар | Д.Нямсамбуу, Ё.Мөнхзул | |
| 3-1-2 | б/” Бидний хот-бидний гэр” хөдөлгөөн өрнүүлж Улаангом хотын тохижилт соёлжилтын талаар аймаг, сумын ИТХ, Засаг дарга нараас гаргасан шийдвэрүүдийн биелэлттэй танилцах, хэрэгжилтийг эрчимжүүлэх үзлэг, өдөрлөг зэрэг арга хэмжээ зохион байгуулах, Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах, жишиг үнэ, жишиг зургаар барилга байгууламж, зогсоол зэргийг барих нөхцөл бүрдүүлэх | 2-р сараас | НУХАХороо, Улаангом сумын ИТХ, ГХБХБАлба | Ш.Цэдэнбал, Б.Жавхлантөгс, Г.Отгонболд | |
| 3-1-3 | в/ “Авто зогсоол-соёлтой үйлчилгээ” хөдөлгөөн өрнүүлж гудамж төслийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх, замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, нийтийн тээвэр, буудал, зогсоолын стандарт хангуулах, | 3-р сараас | ТСЭЗХХороо, ТАЗГазар | Т.Эрдэнэбат, Дэмбэрэлнямбуу | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | түүний болон ойр орчмынхоо замын байгууламжийн талаарх байгууллагын хүлээх үүргийг хангуулах, эзэнжүүлэх , авто осол гэмтлийг бууруулах чиглэлийн мэдээлэл сурталчилгаа, зохион байгуулалтын ажил өрнүүлэх | | | | |
| 3-1-4 | г/Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд ”Ногоон байгууламж-Ногоон хөгжил” хөдөлгөөн өрнүүлж төв суурин газрууд, нийтийн эзэмшлийн болон байгууллагуудын орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, түүний арчлалт хамгаалалтыг шийдвэрлүүлэх, сум дундын ойн ангиудын үйл ажиллагаа, “Ус “ дэд хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлыг зохион байгуулах | 4-р сараас | БОЭТБХороо, БО-ны газар | Э.Насанбат, Б.Ганболд | |
| 3-1-5 | д/ “Сэтгэдэг сургууль-Бүтээдэг аймаг “ зорилтын хүрээнд “Аймгийн хөгжил-Мэргэжилтний ур чадвар” хөдөлгөөн өрнүүлж мэргэжлийн боловсролын талаар баримтлах бодлого гаргах, гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулах, энэ чиглэлээрх түншлэлийг хөгжүүлэх, АОЭХ, мэргэжлийн холбоод, ҮЭ зэргийн оролцоо, санаачлагыг дээшлүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх,”Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах “ дэд хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлыг зохион байгуулах | 3-р сараас | ХХНАХороо, Улаангом коллеж | Л.Наранцэцэг, Ж.Буянтогтох | |
| 3-1-6 | Хорооны хурлаар зохиосон ажлын үр дүнгээ хэлэлцэн нэгтгэж хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах, тэргүүлэгчид, хуралдаанд тайлагнах ажлыг зохион байгуулна. | Улиралд 1 удаа | Хороод | Хороодын дарга нар | |
| **3-2** | Дараах асуудлаар **ярилцлага хэлэлцүүлэг явуулж, хорооны санал дүгнэлт г**аргана. Үүнд: | Жилдээ | Хороод, хариуцсан ажилтнууд | -“- | |
| 3-2-1 | Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар аймгийн ИТХ-ын удирдлагаас өгсөн үүрэг хуваарийн дагуу | Тухай бүрийд | -“- | -“- | |
| 3-2-2 | Аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар өөрийн эрхлэх болон хувиарлагдсан асуудлаар | -“- | -“- | -“- | |
| **3-3** | Шаардлагатай үед аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, даргын шийдвэрээр **түр ажлын хэсэг, түр хороо** томилон ажиллуулж тухайн асуудлаар судалгаа хийлгэх, санал дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулна | Тухай бүрийд | -“- | -“- | |
| **4** | **Ажлын алба**ны зөвлөлгөөнийг сард 2-оос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүрийд нь хийж төлөвлөгдсөн ажлуудыг сар улиралын хуваарьт оруулан тухайн сар улиралд явуулах | Сар бүр | Ажлын албаны ажилтнууд | Б.Оюунбат | Ажлын алба тогтмол, шуурхай, тогтвортой ажил |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гол үйл ажиллагаа, нэрэмжит ажлуудыг тодруулж, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ, ажил үүргийн хуваарьт тусган хэрэгжилтийг хангуулах ажлыг шуурхай зохион байгуулах | | | | лаж, шаардлага-тай арга хэмжээг зохион байгуулж |
| 4-1 | Ажлын албаны ажилтнууд аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны онцлог, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд төрөлжүүлэн боловсруулсан ажлын байрны тодорхойлолтын дагуу болон ажлын шаардлагаар цаг үеийн асуудлаар хувиарласан ажлуудыг хариуцан, үр дүнгээ хагас жилээр нэгтгэн дүгнүүлж ажиллах | Жилдээ | -“- | -“- | Аймгийн ИТХ-ын ажлын төлөвлөгөөг бүрэн хэрэг-жүүлэх нөхцөл бүрдүүлсэн байх |
| 4-2 | Ажилтнууд өөрийнх нь эрхлэх асуудлын онцлогтой уялдуулсан хуваарийн дагуу хурлын 1 хороог хариуцан ажиллаж үйл ажиллагаанд нь байнгын дэмжлэг үзүүлэх | -“- | -“- | -“- | |
| **5.** | **Сум, багийн Иргэдийн хурал**тай аймгийн ИТХ , тэргүүлэгчид, хороод, ажлын албанаас тогтмол харилцаж, хамтран ажиллах асуудал. Үүнд: | Жилдээ | Ажлын алба, сумдын ИТХ-ын удирдлага | Ч.Чимэд | Аймаг сумдын НӨУБ-дын харилцаа хамтын ажиллагаа бэхжиж , сум, багийн хурлын ажилд дэмжлэг болсон байх |
| 5-1 | Сумын ИТХ-ын болон тэргүүлэгчдийн, багийн ИНХ-ын тоо давтамж , хийх хугацаа, зайлшгүй хэлэлцэх, тайланг нь сонсох зэрэг асуудлаар зөвлөмж өгөх | 1-р улиралд | -“- | Б.Оюунбат | |
| 5-2 | Иргэний танхимын ажил болон иргэдийн дунд хэлэлцүүлэг, санал асуулга, судалгаа явуулах сэдэв хугацааны талаарх чиглэл өгч , түүний гүйцэтгэлийн мэдээллийг авах | -“- | -“- | Ч.Чимэд | |
| 5-3 | НӨУБ-ын үйл ажиллагааны онцлог, дотоод ажлын зохион байгуулалт, арга хэлбэрийг боловсронгуй болгох болон хууль эрх зүйн зөвлөлгөө, тогтмол гаргах тайлан мэдээлэл, мониторинг, хяналт шалгалт түүний үр дүнгийн үнэлгээ | Жилдээ | -“- | Б.Оюунбат | |
| 5-4 | Ажлын хариуцлага, сахилга бат, ажил амралтын хуваарь, цаг үеийн шаардлагаар шуурхай зохион байгуулах зэрэг бусад асуудлууд | Жилдээ | -“- | Ч.Чимэд, Б.Оюунбат | |
| **Хоёр.** | **Сургалт, семинар, зөвлөлгөөн зэрэг дангаараа болон хамтран зохион байгуулах ажил, арга хэмжээ** | | | | |
| **6-1-1** | Сумдын ИТХ-ын дарга нарын семинар, цугларалт 2 удаа | 1,12-р сард | Ажлын алба, ЗДТГ | Ч.Чимэд, Д.Цэндсүрэн | Төлөвлөгдсөн арга хэмжээг хугацаанд нь, чанарын өндөр гүйцэтгэлтэйгээр, хангалттай ирц |
| 6-1-2 | Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын семинар, сургалт 2 удаа | 3,9-р сар | Ажлын алба | Ч.Чимэд | |
| **6-2** | **“ НӨУБ-ыг чадавхийг бэхжүүлэх нь “ төсөл**тэй хамтран ажиллаж : | | Ажлын алба | | |
| 6-2-1 | Эмэгтэй төлөөлөгчдийн сургалт | 1-р сар | Төслийн нэгж | Б.Оюунбат | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6-2-2<br>6-2-3<br>6-2-4<br><br><br>6-2-5 | Сургагч багш нарын ээлжит цугларалт<br>Хурлын төлөөлөгчдөд зориулсан ахисан шатны чадавхижуулах сургалт<br>Цахим хуудас ажиллуулах сургалт болон хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаарх хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээнүүдэд холбогдох хүмүүсийг зохион байгуулан оролцуулах<br>Дээрх төсөл болон бусад асуудлаар удирдах байгууллагуудаас өгсөн чиглэл, удирдамжийн хэрэгжилтийг хангуулж сургалт цугларалтыг орон нутагт зохион байгуулах . | 3-р сар<br>Жилдээ<br>-“-<br><br><br>Тухай бүрийд нь | -“-<br>-“-<br>-“-<br><br><br>Ажлын алба | -“-<br>-“-<br>-“-<br><br><br>Б.Оюунбат | оролцоотойгоор зохион байгуулж, үр дүнд нь оролцогчдын чадавхи дээшилж, тухайн асуудлаар тавьсан зорилго биелсэн байх |
| **6-3** | “**Мерси кор “** төслийн нэгжтэй хамтран “ Багийн ИНХ-ын дарга нарын семинар сургалтыг зохион байгуулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх | 6-р сар | Ажлын алба, Төслийн нэгж | Ч.Чимэд | |
| 6-4 | ЕТГ,УИХ-ын ТГ, ЗГХЭГ, ТАЗ, ЦАУЗБУК, АТГ, СЕХ, ХЗЯ-ны ГХУСА, Иргэний зөвлөл, Ахмад зөвлөхүүдийн ажил эрхэлдэг зэрэг ажил төрлийн холбоотой төр захиргааны байгууллага, Монголын НУХ болон бусад иргэний нийгэм, ТББ, төсөл хөтөлбөрийн газруудаас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, сургалт семинарт холбогдох албан тушаалтан, ажил хариуцсан хүмүүс, төлөөлөгчдийг аль болох өргөнөөр оролцуулах ажлыг тухай бүрийд нь зохион байгуулах | Жилдээ | Ажлын алба | Ч.Чимэд | |
| 6-5 | Үндсэн хуулийн өдөр, Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр бусад баяр ёслол зэрэг улсын хэмжээнд , түүнчлэн аймаг, байгууллагын хүрээнд тэмдэглэх ёслол хүндэтгэлийн болон соёл спорт, олон нийтийн арга хэмжээг холбогдох талуудтай хамтран төлөвлөж зохион байгуулах | Жилдээ | Ажлын алба | Ч.Чимэд | |
| 6-6 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба, сумдын ИТХ-ын төлөөллийг оролцуулсан үзүүлэх, туршлага судлах, солилцох арга хэмжээг аймгийн хэмжээнд тусгайлсан сэдэв, зориулалтаар 2 удаа зохион байгуулах | 2,3-р улиралд | Ажлын алба | Ч.Чимэд | |
| 6-7 | Аймгийн ИТХ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөгжүүлэх чиглэлээр 1 арга хэмжээг бэлтгэл хангаж, санхүү зардлын эх үүсвэрийг шийдвэрлүүлэн зохион байгуулах, арга хэмжээ авах | Жилдээ | Ажлын алба | Ч.Чимэд | |
| 6-8 | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч Ө.Бадрахын мэндэлсний 120 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал хийх | 9-р сар | ЦАУЗБ улсын болон аймгийн комисс, бусад байгууллага | Ч.Чимэд | |
| 6-9 | Баруун бүсийн аймгуудын НӨУБ-ын спортын болон бусад нэгдсэн арга хэмжээнд аймгийн төлөөлөл, баг бүрэлдэхүүнийг зохион байгуулж оролцуулах | Жилдээ | Ажлын алба | Ч.Чимэд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Гурав.** | **Мэдээлэн тайлагнах,судлан боловсруулах, шийдвэрлүүлэх, сурталчилгааны ажил** | | | | |
| **7-1** | 2014 оны ажлын үр дүнг тооцож **тайлагнах**. Үүнд: | | | | |
| 7-1-1 | Ажилтнуудын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлэх, ажлын тайланг гаргаж үр дүнгийн гэрээг дүгнэж урамшуулал олгох, хариуцлага тооцох | 1-р сар | Ажилтнууд | Б.Оюунбат | Мэдээ тайланг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлсэн байх |
| 7-1-2 | 2014 оны ажлын тайлан, мэдээг гаргаж хянан баталгаажуулж холбогдох ажил төрлийн холбоо бүхий байгууллагуудад хүргүүлэх Үүнд: | 1-р улиралд | Ажлын алба | Ч.Чимэд | |
| | а/ Аймгийн ИТХ-ын 2014 оны ажлын тайлан, үйл ажиллагааны мэдээ, сарын ажлын мэдээг ЗГХЭГазарт | 2-р сар, сар бүр | Н.Энхжаргал, Д.Энхцэцэг | Б.Оюунбат | |
| | б/ ТАХ-дын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг ТАЗ-д | 1-р сар | Ц.Бямбаханд | Б.Оюунбат | |
| | в/ХАСХОМ гаргагчдын нэр, мэдүүлгийн нэгтгэл, улиралын мэдээг АТГ-д | 1-р сар, улиралд | Н.Энхжаргал | Б.Оюунбат | |
| | г/ГХУСА-ын жилийн болон улиралын ажлын мэдээ, тайланг ГХУСАЗЗ-д | Улиралд | Н.Энхжаргал | Ч.Чимэд | |
| | д/Цагаатгалын комиссын 2014 оны 4-р улиралын болон жил эцсийн тайлан, үйл ажиллагааны мэдээ, нөхөх олговор олгосон тайланг ЦАУЗБУК-д | Улиралд | Б.Оюунбат | Ч.Чимэд | |
| | е/Нөхөн сонгууль, бусад сонгуулийн ажилтай холбоотой мэдээ, тайланг СЕХ болон бусад холбогдох байгууллагад | Тухай бүрийд | Б.Оюунбат | Ч.Чимэд | |
| | ё/2014 онд захиалж хэвлүүлсэн, бэлтгүүлж авсан шагнал, дурсгалын зүйл, ном хэвлэл, гишүүн байгууллагын татвар, хандив , бусад эд аж ахуйн зүйлийн зарцуулалт, нийлүүлэлтийн тайланг гаргаж холбогдох тооцоог НУХ болон холбогдох бусад байгууллагатай хийх | 1-р сар | Ц.Хонгорзул | Б.Оюунбат | |
| | ж/ 2014 оны төсвийн гүйлгээ, тайлан бланс, татварын болон нийгмийн даатгалын тайлангуудыг гаргаж Аудит болон бусад холбогдох газруудад | 1-р сар | Ц.Хонгорзул | Б.Оюунбат | |
| | з/Төсөвт болон ААНБ-ын ТӨХ-1-11, ТӨ-1-15 тайланг гаргуулж ТӨХ, ҮСХ-д хүргүүлэх | Тухай бүрийд | Г.Тунгалаг, Р.Соёлмаа | Б.Оюунбат | |
| 7-1-3 | 2014 оны ажлын үр дүнгээр нь сумдын ИТХ, тэдгээрийн ажилтнуудын ажлыг дүгнэх | 1-р сар | Ажлын алба Б.Оюунбат | Ч.Чимэд | |
| **7-2** | 2015 оны ажилтай холбогдуулан **төлөвлөх, боловсруулах** асуудал. Үүнд: | | | | Төлөвлөгөө төс-лүүд хийгдэж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7-2-1 | а/ Аймгийн ИТХ-ын 2015 оны ажлын төлөвлөгөө, нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалтын төсөл хийж хэлэлцүүлэн батлуулах<br>б/2015 онд хариуцах ажлаар үйл ажиллагааны төлөвлөгөө хийж үр дүнгийн гэрээ,ёс зүйн дүрмийг сахиж ашиг сонирхолын зөрчилгүй ажиллах гэрээ байгуулах<br>в/ГХУСАЗСзөвлөлийн 2015 оны ажлын төлөвлөгөөний төсөл хийж батлуулах<br>г/ЦАУЗБСК-ын 2015 оны ажлын төлөвлөгөөний төсөл хийж батлуулах<br>д/Аймгийн ИТХ-ын ажлын алба, төлөөлөгчдийн 2015 оны төсөв, зардлын хувиарлалтын төсөл хийж төсвийн шууд болон ерөнхийлөн захирагчдаар хянуулан батлуулах | 1-р сар<br>1-р сар<br>1-р сар<br>1-р сар<br>1-р сар | Б.Оюунбат<br>Ажилтнууд<br>Н.Энхжаргал<br>Б.Оюунбат<br>Б.Оюунбат, Ц.Хонгорзул | Ч.Чимэд<br>Б.Оюунбат<br>Ч.Чимэд<br>Ч.Чимэд<br>Ч.Чимэд | хянан баталгаа-жиж түүний дагуу тухайн асуудал зохион байгуулаг-даж хамрагдах талуудыг бүрэн оролцуулсан, асуудал шийдвэр-лэгдсэн байх |
| 7-2-2 | 2015 оны зорилт, төсөв, ажил үүргийн болон бүтцийн өөрчлөлтийг харгалзан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд өөрчлөлт оруулах ажлын хэсэг томилуулан ажиллуулж шинэчилсэн ажлын байрны тодорхойлолтуудыг батлуулж мөрдүүлэх | 1-р сар | Н.Энхжаргал, Б.Баяртсайхан | Б.Оюунбат | |
| 7-2-3 | Аймгийн ИТХ-аас УИХ-ын гишүүдтэй харилцах, хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа авах асуудлаарх саналын төсөл бэлтгэх, шийдвэрлүүлэх | 2-р сард | НУХАХороо, Ш.Цэдэнбал, Д.Энхцэцэг | Ч.Чимэд | |
| 7-2-4 | Хурлын хороод болон төлөөлөгчид,ажлын алба, ГХУСАЗЗ, иргэний зөвлөлөөс ажлаа сурталчлах, иргэдэд мэдээлэл хүргэх, тавьсан асуултанд нь хариу өгөх зорилготой орон нутгийн ТВ-үүдээр тогтсон хугацаанд явуулдаг Төлөөлөгчийн цаг, Ярилцах цаг зэрэг нэвтрүүлэг, мэдээллийн цагтай болох , түүнд оролцох хуваарь, өгөх мэдээллийн төрлүүдийн талаар төсөл бэлтгэх, шийдвэрлүүлэх | 2-р сар | Н.Энхжаргал, Д.Хатанбаатар, Н.Төгөлдөр | Ч.Чимэд, Б.Оюунбат | |
| 7-2-5 | Хурлын хороод, төлөөлөгчид, ажлын алба бусад хурлын дэргэдэх байгууллагуудаас сум байгууллагад явж ажиллах, үйл ажиллагаатай нь танилцах, багийн ИНХ-д оролцох, хяналт шалгалт, мониторинг хийх нэгдсэн удирдамж, хуваарийн төсөл бэлтгэж шийдвэрлүүлэн мөрдүүлэх | 3-р сар | Б.Оюунбат, Н.Энхжаргал, Б.Баяртсайхан | Ч.Чимэд | |
| 7-2-6 | Хурлын төлөөлөгчидөөс сумдын ИТХ-тай хамтран сонгогдсон тойрогтоо “Нэгдсэн өдөрлөг”, “Нэрэмжит ажил” зохион байгуулах удирдамж, хуваарийн төсөл хийж шийдвэрлүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавьж үр дүнг нэгтгэн тайлагнах | 3-р сараас, жилдээ | Д.Энхцэцэг, Н.Төгөлдөр, Ц.Хонгорзул | Б.Оюунбат | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7-2-7 | Хурлын хороод, төлөөлөгчдөөс ажлын албан дээр нээлттэй утсаар, иргэний танхимаар иргэдийн саналыг хүлээн авах, тэдэнтэй уулзаж санал хүсэлтийг нь тогтмол сонсох,ТББ, иргэний нийгмийн бүлгүүдтэй хамтран ажиллах байр, техникийн нөхцөл бүрдүүлэх, ажиллах хуваарь, журмын төслүүдийг бэлтгэж, шийдвэрлүүлэх, мөрдүүлэх , үр дүнг нэгтгэн мэдээлэх | 3-р сараас, жилдээ | Н.Энхжаргал Б.Баяртсайхан, Ч.Хатанбаатар, Ц.Хонгорзул | Ч.Чимэд | |
| 7-2-8 | Сумдын иргэний танхимын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, ажилтнуудын томилгооны талаар сумдад өгөх чиглэлээр шийидвэр гаргуулж сумдад хүргүүлж мөрдүүлэх | 1-р сар | Н. Төгөлдөр | Ч.Чимэд | |
| 7-2-9 | 2015 онд ой тэмдэглэх сумдын үүсэн байгуулагдсан түүхийн талаар аймаг сумдын ЗДТГ-уудтай хамтран түүхийн лавлагаа гаргуулах ажлыг зохион байгуулж, зохих шийдвэр гаргуулах | 1-р сард | Н.Энхжаргал | Ч.Чимэд | |
| 7-2-10 | Цагаатгалын асуудлаар урьд нь гаргасан нэхэмжлэгчдийг тодруулах, шинээр нэхэмжлэл гаргагчдын бичиг баримтанд үзлэг явуулж зөвлөлгөө өгөх, хэлмэгдүүлэлтийн түүхэнд холбогдох асуудлаар судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, зарим арга хэмжээг зохион байгуулах зэрэг асуудлаар санал, төсөл бэлтгэж шийдвэрлүүлэх | Жилдээ | Б.Оюунбат | Ч.Чимэд | |
| 7-2-11 | Ажлын төлөвлөгөөнд туссан өөрийн ажлын байрны тодорхойлолтоор хариуцах асуудлаар дангаараа болон хамтран зохион байгуулагдах ажлын хөтөлбөр төлөвлөгөө, зардлын төсөв, гаргах албан тоот, бусад шаардлагатай албан баримтын төслийг бэлтгэж хянуулан шийдвэр-лүүлж байх | Тухай бүрийд нь | Бүх ажилтнууд өөрийн хариуц сан асуудлаар, Ц.Хонгорзул | Б.Оюунбат | |
| 7-2-12 | Аймгийн ИТХ-ын ОНӨ-ийг өмчлөгчийн үүргийг хангуулах асуудлаар явуулах бодлого үйл ажиллагаанд ахиц гаргахуйц ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, ялангуяа дулааны шугамын түрээсийн төлбөрийг төлөх, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, санхүү төсвийн асуудлаар хийсэн хяналт шалгалт, аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмж шийдвэрүүдийн хэрэгжилтийг хурлын төлөөлөгчид, холбогдох хороодод мэдээлэх, үр дүнг нэгтгэн сурталчлах зэрэг асуудлаар тодорхой ажлуудыг санаачлан боловсруулж шийдвэрлүүлэх | Жилдээ | Б.Баяртсайхан, Г.Тунгалаг, Р.Соёлмаа | Ч.Чимэд | |
| 7-2-13 | Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих Аймгийн ИТХ-ын чиг үүргийг хангуулах, ялангуяа гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх | Жилдээ | Н.Энхжаргал, Н.Төгөлдөр | Ч.Чимэд | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамгаалах байр байгуулах, энэ чиглэлээр хийх мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх, олон нийтийн цагдаа, иргэний зөвлөлийг үр дүнтэй ажиллуулхад шаардлагатай зохион байгуулалт, санхүү төсвийн асуудлыг шийдвэрлүүлэх, иргэний нийгэм төрийн бус байгууллагууд, ажил мэргэжлийн холбоодын үйл ажиллагааны ил тод байдал, дотоод бүтэц зохион байгуулалт, ажлаа олон нийт, гишүүддээ тайлагнах зэрэг асуудлаарх журам, дүрмийн шаардлагыг хангуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, тодорхой асуудлаар санал төсөл бэлтгэж зохих шатанд тавьж шийдвэрлүүлэх | | | | |
| 7-2-14 | Сум агентлагуудтай орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулж, дүгнэх | Жилдээ | Б.Баяртсайхан, Г.Тунгалаг, Р.Соёлмаа | Б.Оюунбат | |
| 7-2-15 | Орон нутгийн өмчит байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу ашиглалт эдэлгээний норм дууссан хөрөнгийг шийдвэрлүүлэх, борлуулах ажлыг зохион байгуулах, орлогыг төвлөрүүлэх, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах , хөрөнгө оруулалттай холбоотой зөвшөөрөл, хүлээлцэх, тооцоо, хяналтын зэрэг цаг үеийн ажлуудыг зохион байгуулах | -“- | -“- | Б.Оюунбат | |
| 7-2-16 | НӨУБ болон орон нутгийн ажил амьдралтай холбоотой хууль тогтоомж, бусад шийдвэр журмуудыг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар гарсан санал, хүсэлтүүдийг холбогдох талуудад уламжилж шийдвэрлүүлэх, энэ чиглэлээрх арга хэмжээ, хэлэлцүүлэг, санал асуулгыг явуулах, холбогдох талуудыг оролцуулах ажлыг зохион байгуулах | Жилдээ | Ажлын алба | Б.Оюунбат | |
| **7-3** | **Мэдээлэл, сурталчилгаа**ны ажлууд. Үүнд: | | | | |
| 7-3-1 | Аймаг, сумдын ИТХ-ын ажлын явц , үр дүнг орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, “Нутгийн удирдлага” сэтгүүлд цувралаар сурталчлах ажлыг зохион байгуулах | Жилдээ | Бүх ажилтнууд өөрийн хариуц сан асуудлаар | Б.Оюунбат | Мэдээлэл суртал - чилгаа, зохион байгуулах, бэлтгэх ажлуудыг хариуц-сан ажилтнууд нь зохих хугацаандаа хэрэгжүүлснээр аймгийн ИТХ-ын |
| 7-3-2 | / www.khural.uv.gov.mn , Uvs.khural.mn , www. Uvsnutag.mn / сайтуудад тогтмол, www.ontlokh.mn сайттай 2015 онд хамтран ажиллах гэрээг шинээр байгуулж хамтран ажиллах, дээрх сайтууд болон Facebook /groups/ uvs.ith Youtube.com / Увс аймаг ИТХ хуудсуудад аймгийн НӨУБ-дын ажлын мэдээ, мэдээллийг тухай бүрийд | Жилдээ | Н.Төгөлдөр, Ч.Хатанбаатар | Б.Оюунбат | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | нь байршуулж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ-д энэ чиглэлээр зөвлөлгөө өгч, дэмжлэг үзүүлэх | | | | үйл ажиллагааны тухай мэдээлэл хүргэхээр төлөв-лөсөн талуудад зохих хугацаандаа хүрч байгуул-лагын маркетин-гийн зорилт хангагдсан байх |
| 7-3-3 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны хэмжээнд болон сумдын ИТХ-ын ажилд Webmail.gov.mn, ablecloud/intranet /, microsoft office /outlook / программуудыг бүрэн нэвтрүүлэх, ажлын албаны нийт ажилтнууд, сумдын ИТХ-ын н/б дарга нарт болон бусад шаардлагатай хүмүүст албаны цахим хаяг нээж, саатэлгүй ажиллуулах нөхцөл бүрдүүлэн тэднийг тогтмол ашиглаж сурхад нь дэмжлэг үзүүлэх | 1-р сараас, жилдээ | Н.Төгөлдөр, Ч.Хатанбаатар | Ч.Чимэд | |
| 7-3-4 | Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрүүд, бусад танилцуулах мэдээллийг аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ-уудад цахим хэлбэрээр шуурхай мэдээлэх, хүлээн авсан эсэхийг нь тухайн асуудлыг хариуцсан ажилтнууд тухай бүрийд нь шалгаж шаардлагатай бол цаасаар хүргүүлэх, хариу мэдээллийг хугацаанд нь авч нэгтгэх, дүнг танилцуулах ажлыг зохион байгуулдаг журмыг тогтмол мөрдүүлж хэвшүүлэх | 1-р сараас, жилдээ | Ц.Бямбаханд, Ч.Хатанбаатар болон бусад ажилтнууд | Б.Оюунбат | |
| 7-3-5 | Аймгийн болон сумдын ИТХ-ын ажлын цаг үеийн мэдээллээр сар бүр “онцлох мэдээ”-ний хуудас бэлтгэж цахимаар болон цаасаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ-ууд болон бусад холбогдох талуудад хүргүүлэх, сайтуудад байршуулах | Сар бүр | Н.Төгөлдөр, Ч.Хатанбаатар | Б.Оюунбат | |
| 7-3-6 | НӨУБ-ын ажлын арга барил, хэлбэрийг боловсронгуй болгох талаарх арга зүйн зөвлөмж, нийтлэг ач холбогдол бүхий удирдамжийн шинж чанартай шийдвэр зэрэг удаан хугацаанд мөрдөх баримт бичгүүдийг гарын авлага болгож эмхэтгэсэн бичмэл сэтгүүл бэлтгэж сумдын ИТХ-ууд болон бусад холбогдох талуудад хүргүүлэх | Улирал бүр | Н.Энхжаргал, Б.Баяртсайхан, Д.Энхцэцэг | Б.Оюунбат | |
| 7-3-7 | Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, хурлын хороод, төлөөлөгчид, сумдын ИТХ болон бусад холбогдох байгууллагуудад хүргэх зар мэдээг цахим болон утас бусад хэлбэрээр шуурхай хүргэж тухайн арга хэмжээний ирц, орол цоог бүрэн бүрдүүлэх, ажлын алба бусад харилцагч талуудыг харилцаа холбооны лавлагаа, мэдээллээр хангах , тараасан материал, ном хэвлэлийн бүртгэл, түүний бүрэн хүртээмжтэй шуурхай байдлыг хангаж, бичиг хэрэг, архивын ажлыг стандарт, журмын хүрээнд эрхлэн явуулах | Жилдээ | Ц.Бямбаханд | Б.Оюунбат | |
| 7-3-8 | Мэдээллийн самбар болон бусад хэрэгслээр иргэд, бусад талуудад | Жилдээ | Нийт | Б.Оюунбат | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хүргэх мэдээллийг цаг үеийн ажлын мэдээгээр баяжуулан тогтмол шинэчилж шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах | | ажилтнууд | | |
| 7-3-9 | Бэлэг дурсгал, сурталчилгааны зориулалтаар 2013-2014 оны ажлын үр дүнг үндэслэн шинэлэг ажлын цомог календарь бэлтгэх хэвлүүлэх ажлыг дуусгах | 1-р сар | Б.Баяртсайхан<br>Н.Төгөлдөр | Ч.Чимэд | |
| 7-3-10 | Аймгийн ИТХ-ын 2014 оны, ГХУСАЗСЗ-ийн 2013-2014 оны ажлын үр дүнгээр олон нийтэд тараах зориулалттай гарын авлагын эх бэлтгэх, хэвлүүлэх | 1-р сар | Н.Энхжаргал,<br>Н.Төгөлдөр,<br>Ч.Хатанбаатар | Б.Оюунбат | |
| 7-3-11 | Аймгийн ИТХ-ын 2014 оны ажлын тайланг үндэслэн 20 минутын хугацаанд үргэлжлэх бичлэг бэлтгэж , ТВ болон бусад хэлбэрээр олон нийтэд тайлагнан сурталчлах , бусад арга хэмжээнд ашиглах | 2-р сар | Б.Оюунбат,<br>Ч.Хатанбаатар,<br>Н.Төгөлдөр | Ч.Чимэд | |
| 7-3-12 | Орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийг “Онлайн “ программд оруулах ажлыг зохион байгуулах | Эхний хагаст | Б.Баяртсайхан,<br>Г.Тунгалаг,<br>Р.Соёлмаа | Ч.Чимэд | |
| 7-3-13 | Аймгийн 2015 оны сургалт семинарын график, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойд бэлтгэх төлөвлөгөө, энэхүү ойг угтаж байгууллагуудаас хийх ажлын жагсаалт зэрэг орон нутгийн цаг үеийн асуудлууд болон НӨУБ-ын бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг улсын хэмжээний тулгамдсан асуудлаар холбогдох талуудыг оролцуулан аймгийн ИТХ, ажлын албаны албан ёсны саналын төсөл бэлтгэж шийдвэрлүүлэх , хүргүүлэх ажлыг зохион байгуулах | Тухай бүрийд нь | Н.Энхжаргал,<br>Б.Баяртсайхан | Б.Оюунбат | |
| **Дөрөв.** | **Хяналт шалгалтын ажил** | | | | |
| **8-1** | **Аудит**ын байгууллагад **захиалга өгч** хийлгэх гүйцэтгэлийн болон нийцлийн аудит. Үүнд: | Жилдээ | Аудитын газар | Ч.Чимэд,<br>Б.Авирмэд | Төлөвлөсөн хяналт шалгалт, аудит хийгдэж аймгийн ИТХ-аас гаргасан шийдвэ-рийн хэрэгжилт үр дүнд сайн нөлөө үзүүлснээр дэвшүүлсэн зорилт хангагдсан |
| 8-1-1 | Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэлд болон ОНХС-ийн санхүүжилтаар хийгдсэн ажил, хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн биелэлтэнд | -“- | -“- | -“- | |
| 8-1-2 | Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зарцуулалт, эргэн төлөлтийн байдалд | Жилдээ | Аудитын газар | Б.Авирмэд | |
| 8-1-3 | Аймгийн татварын орлогын нөөцийг бүрэн тооцох, төлөвлөх, орлого бүрдүүлэлтэнд тавих хяналтыг сайжруулах асуудлаар | -“- | -“- | -“- | |
| 8-1-4 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр улсын төсвөөс | -“- | -“- | -“- | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зарцуулсан хөрөнгийн үр ашиг, усны ашиглалт хамгаалалтын асуудлаар | | | | байх |
| **8-2-1** | Аймгийн Төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчид, зарим шууд захирагчдын санхүү төсвийн үйл ажиллагаанд **түүвэр аудит** хийж үр дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, хурлын холбогдох хороодод танилцуулах | Жилдээ | Аудитын газар | Б. Авирмэд | |
| **8-3-1** | Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрүүд, хуралдаан дээр гарсан санал шүүмжлэлээр хөндөгдсөн асуудлуудад үндэслэн төсөв санхүүгийн чиглэлээр **хэсэгчилсэн хяналт, дотоод аудит**ыг 10 сум, 70-д төсвийн байгууллагад хийж дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, холбогдох хурлын хороо болон тухайн төлөөлөгчид мэдээлэх | Жилдээ | Санхүүгийн хяналт,аудитын алба | Л.Чойжилсүрэн | |
| **8-4** | Аймгийн **ИТХурлын удирдамж, ГХУСАЗСЗ, ажлын албаны** шугамаар хийх хяналтын ажлууд. Үүнд: | | | | |
| 8-4-1 | Аймгийн ИТХ-ын 8-р хуралдаан дээр гарсан санал шүүмжлэл, асуулт асуулгыг холбогдох байгууллагуудад хүргүүлж судлан шийдвэрлүүлэх, зорилт төлөвлөгөөнд нь тусгуулах арга хэмжээ авч, үр дүнг нэгтгэн холбогдох талуудад хариу өгүүлэх ажлыг зохион байгуулах | 1-р сараас | Д.Энхцэцэг, Ц.Бямбаханд | Б.Оюунбат | |
| 8-4-2 | Аймгийн ИТХ-ын даргын захирамж, удирдамжаар: | | | | |
| | а/ Шаардлагатай үед түр ажлын хэсэг,түр хороо байгуулан тухайн асуудлаар хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах | Жилдээ | Ажлын хэсгийн ахлагч нар | Ч.Чимэд | |
| | б/Хурлын хороодоос эрхлэх асуудлынхаа хүрээнд хийхээр төлөвлөсөн хяналт шалгалт, танилцах ажлууд | -"- | Хороодын дарга нар | Ч.Чимэд | |
| | в/ Сумдын ИТХ-д мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажлын үр дүнд нь мониторинг хийх | 6,11-р сар | Ажлын алба, Б.Оюунбат | Ч.Чимэд | |
| | г/Санхүү хууль хяналтын байгууллагуудтай хамтран ОНӨ-ийн хөрөнгөнд тооллого явуулах, хандив, зээл тусламж, хөрөнгө оруулалтаар ирсэн болон бүртгэлд тусгагдаагүй хөрөнгийн талаар үзлэг шалгалт хийх | Жилдээ | Ажлын алба, Г.Тунгалаг, Р.Соёлмаа | Б.Оюунбат | |
| | д/ ГХУС, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэдээлэл, өргөдөл гомдолыг барагдуулах чиглэлээр нийт 228 сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжийг хамарсан хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах | Жилдээ | ГХУСАЗСЗ, холбогдох байгууллагууд | Ч.Чимэд | |
| **Тав.** | **Аж ахуйн болон бусад асуудал** | | | | |
| 9-1-1 | Аймгийн ИТХ-ын 2015 оны үйл ажиллагааг явуулахад шаардагдах худалдан авалтын гэрээ, хэлцэлийг ТВ, сонин, хэвлэлийн цех, ШТС, цайны газар, ресторан зэрэг холбогдох тал, үйлчилгээ үзүүлэх | 1-р сараас | Б.Оюунбат, Ц.Хонгорзул | Ч.Чимэд | Аливаа арга хэмжээг санхүү, хүн хүч, материал, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудтай зохих журмын дагуу байгуулах, захиалга өгөх, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийлүүлэх ажлыг зохион байгуулах | | | | зохион байгуулал-тын шаардлагатай нөөцөөр хангаж төлөвлөгдсөн ажлыг тоо, чанарын хувьд бүрэн биелүүлэх нөхцөл бүрдүүлэх |
| 9-1-2 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн ажлын танхимд хууль тогтоомжийн болон НӨУБ-ын асуудлаарх лавлагааны сан бүрдүүлэх ажлыг гүйцээх | 1-р улиралд | Н.Энхжаргал, Д.Энхцэцэг | Б.Оюунбат | |
| 9-1-3 | Тогтмол хэвлэл болон ажилд шаардлагатай ном товхимол лавлагаа, гарын авлагын материалыг захиалан авч холбогдох тооцоог тухай бүрийд хийж байх | Улирал бүрээр | Ц.Хонгорзул | Б.Оюунбат | |
| 9-1-4 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ-ын удирдлага, ажилтнууд, ажлын албаны ажилтнуудын энэ бүрэн эрхийн хугацаанд төвлөрсөн сургалт семинар, гадаад дотоод арга хэмжээнд оролцсон бүртгэл, төр засгийн болон яам системийн, аймгийн шагналаар шагнагдсан байдлын нэрчилсэн судалгааг шинэчлэн бүрэн хийж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр 2-оос дээш удаа сонгогдсон төлөөлөгчдийг төр засгийн шагналд тодорхойлох баримтыг бүрдүүлэх, ажлын албаны хуралд оруулах ажлыг зохион байгуулах | 1-р улиралд | Ц.Бямбаханд, Д.Энхцэцэг | Б.Оюунбат | |
| 9-1-5 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны ажилтнууд, сумдын ИТХ-ын дарга , нарийн бичгийн дарга нарын хувийн хэрэгт шинэчилсэн баяжуулалт хийх | 3-р сард | Ц.Бямбаханд | Б.Оюунбат | |
| 9-1-6 | Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардалд хувиарлалт хийж зохих шийдвэрийн дагуу олгох, нэхэмжлэл гаргасан иргэдэд цагаатгалын нөхөх олговрыг олгох, тэргүүлэгчдийн урамшуулал, ажилтнуудын цалин, бусад зардал, урамшууллыг олгох гүйлгээг шуурхай хийж, төлбөр тооцооны ажилд бэлэн бус шилжүүлэг, картыг бүрэн нэвтрүүлэх, төсвийн ил тод байдал, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Жилдээ | Ц.Хонгорлул | Ч.Чимэд, Б.Оюунбат | |
| 9-1-7 | “НӨУБ-ын чадавхийг бэхжүүлэх “ төслийн нэгжээс 2015 онд зохион байгуулах сургалт, семинарт оролцох асуудлаар төсвийн төсөл хийж, холбогдох тооцоо, мэдээллийг гаргаж хүргүүлэх | 2-р сард | Н.Энхжаргал, Ц.Хонгорзул | Б.Оюунбат | |
| 9-1-8 | Аймгийн ИТХ-ын ажлын албаны өмч хөрөнгийн шинэчилсэн тооллого, бүртгэлийг хийж эвдэрсэн, ашиглахгүй байгаа, ашиглалтын хугацаа дууссан, илүүдэлтэй, элэгдлээ нөхсөн, данс бүртгэлд байдаг болович биет байдлаараа байхгүй үрэгдэж алга болсон зэрэг тоног төхөөрөмж, | 1-р сард | Ц.Хонгорзул, П.Жамбал | Б.Оюунбат | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9-1-9 | техник хэрэгсэл, эд хөрөнгийг актлах, данс бүртгэлээс хасах, шилжүүлсэн болон шинээр авсан хөрөнгийг бүртгэх, шаардлагатай холбогдох шийдвэрийг гаргуулах баримтыг бүрдүүлэх ажил хийж ажлын албаны өмч хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх<br>Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба, сумдын ИТХ-ын болон , бусад харилцагч байгууллагуудын хаяг, утасны бүртгэл зэрэг албан ажилд шаардагдах бүртгэл лавлагааг шинэчлэн холбогдох байгууллага хүмүүст хүргүүлэх | 1-р сард | Ц.Бямбаханд | Б.Оюунбат | |